



**ХЭНТИЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 38

Хэрлэн сум

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан
мэргэжилтний сул орон тоонд томилуулахаар
нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.7, 3.5, 3.5.4 дэх заалт, 2023 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 12.1, 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн албаны тусгай шалгалтад тэнцэж хамгийн өндөр оноо (72,7) авсан Батжаргалын Энх-Уянгыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2.Нэр дэвшигч Б.Энх-Уянгыг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг 30 хоногийн дотор гаргаж, албан бичгээр ирүүлэх шаардлагатайг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д зөвлөсүгэй.

3.Энэхүү тогтоолыг аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Ж.Саруултөгс)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА